

# ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

---

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТ ЯВУУЛСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

2017 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын баталсан удирдамжийн дагуу Хяналт шалгалт, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Ч.Ууганбаяр, цагдаагийн дэд хурандаа С.Гарьдпүрэв нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалтыг 2017 оны 05 дугаар сарын 03-аас 07-ны хооронд явуулж үнэлэлт, дүгнэлт өгч шалган зааварчиллаа.

Төлөвлөгөөт шалгалтын дүнг хэлэлцэн “80,4” буюу “Сайн” гэж дүгнэж Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Үүрэг хүргүүлэх тухай” албан бичгээр тус нэгжид 11 төрлийн үүрэг өгсөн бөгөөд тус цагдаагийн газар нь өгсөн үүргийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, зохион байгуулсан ажил, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар 2016 оны 12 сарын 15-ны байдлаар төлөвлөгөөний биелэлт гаргаж холбогдох материалыг хавсаргаж ирүүлсэн байдалд Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт-шинжилгээ хийж 72,3 буюу “Хангалттай” гэсэн үнэлгээ өгсөн байна.

Өгсөн үүрэгт дурьдагдсан 11 ажил, арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцох 36 шалгуураас:

- хоёр ажлын 2 шалгуурыг маш сайн буюу 90,0-100,0

- есөн ажлын 24 шалгуурыг сайн буюу 80.0-89.0

-таван ажлын 10 шалгуурыг хангалттай буюу 70.0-79.0 оноогоор үнэлж холбогдох тайлбар хийлээ.

Шалгалт явуулсан дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2017 оны 04 дүгээр хуралдаанаар хэлэлцээд Хэнтий аймаг дахь цагдаагийн газар нь төлөвлөгөөт шалгалтын дүнг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2016 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн “Үүрэг хүргүүлэх тухай” албан бичгээр өгсөн үүргийг **81,5** хувь буюу “**Сайн**” үнэлгээтэй хэрэгжүүлсэн гэж дүгнэв.

Хүрвэл зохих түвшингийн зарим үзүүлэлтэд хүрээгүй, хэрэгжилт 70.0-79.0 хувьтай байгаа таван ажлын 10 шалгуурыг хангаж ажиллах талаар Хэнтий аймаг дахь цагдаагийн газар /цагдаагийн дэд хурандаа Ж.Болдод/-д “Мэдээлэл, ажлын чиглэл” хүргүүлэх саналтай илтгэн танилцуулья.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**